

ЭРЧИМ ХҮЧЭЭР АЖИЛЛАДАГ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЦАХИЛГААН БАРААНД ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ, ШОШГОЖУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмын зорилго нь эрчим хүчний үр ашигтай, дэвшилтэт машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан барааны хэрэглээг нэмэгдүүлэх, хуурамч бүтээгдэхүүнээс хэрэглэгчийг хамгаалах, зөв сонголт хийхэд туслах, эрчим хүчний хэмнэлттэй бараа бүтээгдэхүүний зах зээл дэх өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

1.2 Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараа /цаашид “Бараа бүтээгдэхүүн” гэх/ -нд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавихүйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3 Бараа бүтээгдэхүүнд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Өрийн хяналт, шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, норм, стандартыг удирдлага болгон энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.4 Төсөл, хөтөлбөрийн хүрээнд болон үр хугацаанд ашиглах, хилээр буцааж гаргах бараа бүтээгдэхүүнд энэ журам хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.5 Эрчим хүчний үр ашиг нь холбогдох стандарт болон шошго, гэрчилгээгээр баталгаажсан импортын бараа бүтээгдэхүүнийг энэ журмын дагуу шошгожуулахад дахин баталгаажуулахгүй ба тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг, гадаад улс болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх зарчмыг баримтална.

1.6 Шошгожуулах үйл ажиллагаанд үнэн зөв өгөгдөл мэдээлэл, инженерийн тооцоолол, хэмжилт, туршилт, нотолгоонд суурилсан, хараат бус, ёс зүйтэй, нууцыг хадгалах зарчмыг баримтална.

Хоёр. Ангилал, зэрэглэл

2.1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн хэрэглээнд түгээмэл ашигладаг, эрчим хүчний зарцуулалт өндөр, ажиллагааны горим, эрчим хүчний хэрэглээний онцлогоос хамааруулан бараа бүтээгдэхүүнийг заавал шошго авах, сайн дураар шошго авах гэж ангилна.

2.2. Заавал шошго авах бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн эрчим хүчний хэрэглээнд эзлэх хувийн жин, эрчим хүчний хэмнэлт, үр ашиг гарах боломж, эрчим хүчний системийн хоногийн оргил ачаалалд үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан тодорхойлно.

2.3. Энэ журмын 2.2-т заасан шошго заавал авах бараа бүтээгдэхүүний жагсаалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.4. Бараа бүтээгдэхүүний эрчим хүчний зарцуулалт, үр ашгаас хамааруулан дараах байдлаар зэрэглэл тогтооно.

- 1 – маш өндөр үр ашигтай;
- 2 – өндөр үр ашигтай;
- 3 – үр ашигтай;
- 4 – бага үр ашигтай;
- 5 –үр ашиггүй.

2.5. Энэ журмын 2.4-т заасан зэрэглэлийг тогтооход тухайн бараа бүтээгдэхүүний эрчим хүчний зарцуулалт, үр ашгийг тодорхойлох норм, стандарт, аргачлалыг мөрдлөг болгоно.

2.6. Энэ журмын 2.3-д дурдсан жагсаалтад хамрагдаагүй бусад бараа бүтээгдэхүүнд сайн дураар шошго авч болно.

Гурав. Эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ, шошго

3.1. Гэрчилгээ нь энэ журмын 2.5-д заасны дагуу эрчим хүчний үзүүлэлтийг тооцоолон, хэрэглээний зэрэглэлийг тогтоосон, техникийн болон эрчим хүчний хэрэглээний дэлгэрэнгүй мэдээллийг баталгаажуулсан баримт байна.

3.2. Эрчим хүчний хэрэглээний гэрчилгээнд дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулна. Үүнд:

- 3.2.1 Гэрчилгээ олгосон байгууллагын нэр;
- 3.2.2 Гэрчилгээний дугаар;
- 3.2.3 Гэрчилгээ олгосон огноо;
- 3.2.4 Гэрчилгээ олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;
- 3.2.5 Шошго, гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн нэр эсвэл иргэний овог, эцэг эхийн нэр болон өөрийн нэр;
- 3.2.6 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар эсхүл регистрийн дугаар;
- 3.2.7 Энэ журмын 3.5, 3.6-д дурдсан мэдээлэл;
- 3.2.8 Эрчим хүчний хэрэглээний дэлгэрэнгүй мэдээлэл;
- 3.2.9 Эрчим хүчний үзүүлэлт, хэрэглээг тооцсон тохирлын үнэлгээний байгууллагын нэр /төхирлийн үнэлгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан бол/;
- 3.2.10 Эрчим хүчний үр ашигтай нь холбогдох стандартын шаардлагад нийцсэн эсэх мэдээлэл /энэ журмын 3.6-д заасан шошго авах бол/;
- 3.2.11 Бараа бүтээгдэхүүний төрөл, ашиглалтаас хамаарах нэмэлт мэдээлэл /байгальд ээлтэй байдал, нөлөөлөл, материалын тухай гэх мэт/.

3.3. Шошго нь гэрчилгээний хамт үжинтэй бөгөөд эрчим хүчний хэрэглээний хураангуй мэдээллийг агуулсан стандартчилагдсан баримт байх ба энэ журмын хавсралтад заасан загвартай байна.

3.4. Энэ журмын 2.3, 2.6-д заасан шошго нь харьцуулсан, нотолсон гэсэн хоёр төрөлтэй байна.

3.5. Энэ журмын 2.4-т заасны дагуу зэрэглэл тогтоосон бараа бүтээгдэхүүнд харьцуулсан шошго олгох бөгөөд харьцуулсан шошгод дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 3.5.1 Шошгын дугаар;
- 3.5.2 Бүтээгдэхүүний нэр;
- 3.5.3 Бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн лого;
- 3.5.4 Бүтээгдэхүүний загварын дугаар;
- 3.5.5 Эрчим хүчний хэрэглээний зэрэглэл;
- 3.5.6 Эрчим хүчний жилийн хэрэглээ;
- 3.5.7 Бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт;
- 3.5.8 Шошго олгосон эрх бүхий байгууллагын нэр, лого.

3.6. Эрчим хүчний үр ашигтай эсэх нь холбогдох норм, стандартын шаардлагаар тодорхойлогдож буй бараа бүтээгдэхүүнд нотолсон шошго олгох бөгөөд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 3.6.1 Шошгын дугаар;
- 3.6.2 Шошго олгосон эрх бүхий байгууллагын нэр;
- 3.6.3 Эрчим хүчний үр ашгийн стандартын дугаар.

3.7. Худалдан борлуулах бараа бүтээгдэхүүн бүрд шошгыг заавал дагалдуулах бөгөөд хэрэглэгчдэд мэдээлэл өгөх зорилгоор бараа бүтээгдэхүүний нүүр тал, сав, баглаа боодол дээр наах, зар сурталчилгаанд ашиглаж болно.

Дөрөв. Эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ, шошго олгох

4.1. Худалдан борлуулж ашиг олох зорилгоор үйлдвэрлэсэн, импортолсон бараа бүтээгдэхүүнд үйлдвэрлэгч, импортлогчийн нэр дээр энэ журмын 3.5, 3.6-д заасан эрчим хүчний хэрэглээний шошгыг гэрчилгээний хамт олгоно.

4.2. Энэ журмын 2.2-д заасан бараа бүтээгдэхүүнд шошго, гэрчилгээг дор дурдсан хугацаанд авсан байна. Үүнд:

- 4.2.1. үйлдвэрлэгч нь бараа бүтээгдэхүүнийг худалдаанд гаргахаас өмнө;
- 4.2.2. импортлогч нь бараа бүтээгдэхүүнийг гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн хилээр нэвтрүүлэхээс өмнө болон дараа.

4.3. Сайн дурын шошго авахад энэ журмын 4.2-т заасан хугацаанд мэдүүлэхийг шаардахгүй.

4.4. Иргэн, хуулийн этгээд нь үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнд шошго авах хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд гаргана. Үүнд:

- 4.4.1. хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.4.2. патент, ашигтай загварын гэрчилгээний хуулбар;
- 4.4.3. эрчим хүчний хэрэглээний шошго, гэрчилгээгүй бараа бүтээгдэхүүн итгэмжлэгдсэн¹ тохирлын үнэлгээний байгууллагаар эрчим хүчний үзүүлэлт, хэрэглээг тодорхойлуулсан баталгаат дүгнэлт;

4.5. Иргэн, хуулийн этгээд нь импортлох бараа бүтээгдэхүүнд шошго авах хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд гаргана. Үүнд:

- 4.5.1. хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.5.2. шошго авах бараа бүтээгдэхүүний танилцуулга /бүтээгдэхүүний загварын дугаар, зориулалт, барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн код, үйлдвэрлэгч, зураг, хүчин чадлын үзүүлэлт гэх мэт/;
- 4.5.3. бараа бүтээгдэхүүний гарал үүслийг нотлох баримт бичиг, түүний хуулбар;
- 4.5.4. импортын бараа бүтээгдэхүүн нь тухайн орныхоо эрх бүхий байгууллагаас олгосон эрчим хүчний хэрэглээний шошго, гэрчилгээтэй бол шошго, гэрчилгээний эх хувь, хуулбарын хамт;
- 4.5.5. холбогдох норм, стандартын дагуу үйлдвэрлэгдэж үр ашгийн үзүүлэлт нь тодорхойлогдсон бараа бүтээгдэхүүний стандартын шаардлага хангаж буйг илтгэх баримт бичиг, түүний хуулбар;
- 4.5.6. энэ журмын 4.5.5-д заасан баримт бичгийг буюу эрчим хүчний хэрэглээний шошго, гэрчилгээгүй бараа бүтээгдэхүүн итгэмжлэгдсэн² тохирлын үнэлгээний байгууллагаар эрчим хүчний үзүүлэлт, хэрэглээг тодорхойлуулсан баталгаат дүгнэлт;

4.6. Шошгыг бараа бүтээгдэхүүний загвар, төрөл тус бүрд олгоно.

4.7. Бараа бүтээгдэхүүний загвар, төрөл, хэмжээ, хүчин чадал өөрчлөгдөх бүрд шошго, гэрчилгээг дахин авна.

4.8. Энэ журмын 4.4, 4.5-д заасан баримт бичгийн бүрдүүлбэр дутуу тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзана.

4.9. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь бүрдүүлбэрийн үнэн зөв байдлыг тодруулах зорилгоор төрийн болон холбогдох бусад байгууллагаас лавлагаа мэдээлэл авах, ажлын байртай танилцах ажлыг зохион байгуулж болно.

¹Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу

²Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу

4.10. Энэ журмын 4.9-д заасан нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд шошго, гэрчилгээ олгох эсэх асуудлыг 30 хоногт багтаан Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл шийдвэрлэнэ.

Тав. Талуудын эрх үүрэг

5.1. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл дараах эрх, үүрэгтэй байна:

- 5.1.1. энэ журмын 2.5-д заасан аргачлалыг боловсруулах ажлыг зохион байгуулж, батлах;
- 5.1.2. энэ журмын 2.2-т заасан заавал шошго авах бараа бүтээгдэхүүнийг тодорхойлох;
- 5.1.3. энэ журмын 4.1-д заасан шошго, гэрчилгээг олгох;
- 5.1.4. шошго олгох үйл ажиллагаанд энэ журмын 4. 10-д заасан хугацааг мөрдөх;
- 5.1.5. энэ журмыг хэрэгжлэхтэй холбогдох үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- 5.1.6. шошгожуулах үйл ажиллагаанд оролцогч талуудыг шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах;
- 5.1.7. тохирлын үнэлгээний байгууллагатай хамтран ажиллах;
- 5.1.8. эрчим үжний хэрэглээний шошго болон шошгожсон бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 5.1.9. энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих.

5.2. Энэ журмын 4.2, 5.1.3, 5.1.5, 5.1.7, 5.1.9-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор шошгожуулах үйл ажиллагааны уялдааг хангах, мэдээлэл солилцох, хяналтын тогтолцоог хамтран хэрэгжүүлж үүрэг бүхий орон тооны бус Мэргэжлийн комиссыг байгуулж болно.

5.3. Энэ журмын 4.4.3, 4.5.6-д заасан үнэлтийг гаргах т охирлын үнэлгээний байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

- 5.3.1. тооцоо, туршилт, үнэлгээ хийхдээ батлагдсан норм, стандарт, дүрэм, заавар, аргачлалыг мөрдөх;
- 5.3.2. шошгожуулах үйл ажиллагааны хүрээнд хийх тооцоо, туршилт, сорилтыг үнэн зөв, хараат бусаар гүйцэтгэх;
- 5.3.3. шошго хүсэгч, шошго эзэмшигч байгууллагын нууцыг чандлан хадгалж, задруулахгүй байх;
- 5.3.4. тооцоо, үнэлгээ хийсэн ажилдаа мэргэжлийн баталгаат дүгнэлт гаргаж, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах;
- 5.3.5. тооцоо, туршилт, үнэлгээний ажлыг тогтмол явуулах, өргөжүүлэх талаар санаачилгатай ажиллах;

- 5.3.6. өөрийн буруутай үйлдлийн улмаас тооцоо, үнэлгээний ажлыг чанаргүй эсвэл буруу гүйцэтгэснээс үүсэх хариуцлагыг хүлээх.
- 5.4. Шошго хүсэгч, эзэмшигч дараах эрх, үүрэгтэй байна:
 - 5.4.1. шошго хүсэхтэй холбоотой мэдээллийг үнэн зөв өгөх;
 - 5.4.2. Энэ журмын 4.2-т заасан хугацаанд шошго авах;
 - 5.4.3. бараа бүтээгдэхүүн тус бүрд тохирсон шошгыг авах;
 - 5.4.4. батлагдсан загварын дагуу шошгыг хэвлүүлж ашиглах;
 - 5.4.5. шошгожуулах үйл ажиллагаатай холбогдох зардал, санхүүжилтийг хариуцах;
 - 5.4.6. шошгыг хууль бусаар ашиглахгүй байх;
 - 5.4.7. шошго авсан болон авахаарүсэлт гаргаж буй импортолсон, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний тоо хэмжээний тухай мэдээллийг тайлагнах.
 - 5.4.8. шошгын ач холбогдлыг хэрэглэгчдэд сурталчлах, таниулах.

Зургаа. Хориглох нөхцөл

- 6.1. Шошго эзэмшигч нь Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс олгосон эрчим хүчний хэрэглээний шошгыг гуравдагч этгээдэд шилжүүлэх, дамжуулах, шошго аваагүй өөр бүтээгдэхүүнд ашиглах, хуурамчаар үйлдэхийг хориглоно.
- 6.2. Шошго эзэмшигч тухайн барааүбэгд эхүүний эрчим хүчний хэрэглээний шошгыг хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, худал зар сурталчилгаа болон хууль бус үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.
- 6.3. Энэ журмын 6.1, 6.2-т заасан хориглох өжцөлийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 10.25 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 11.21 дүгээр зүйлийн 17 дахь хэсэгт заасан арга хэмжээг авна.

Долоо. Хяналт тавих

- 7.1. Энэ журмын хэрэгжилтэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага хамтарч Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн баталсан удирдамж, хяналтын хуудасны дагуу жилд нэгээс доошгүй удаа хяналт тавина.
- 7.2. Хяналтын үйл ажиллагааг Эрчим хүчний тухай хуулийн 8.4 -т заасан улсын байцаагч ахлах бгөөд энэ журмын хэрэгжилттэй холбоотой зөрчл ийг арилгуулах ажлыг хэрэгжүүлнэ;
- 7.3. Энэ журмын 4.2-т заасны дагуу шошго, гэрчилгээ авч буй эсэхэд холбогдох төрийн хяналтын байгууллага, улсын байцаагч хяналт тавина.

Найм. Бусад

- 8.1. Шошго олгох, хэрэглэхтэй холбогдон үүссэн хүсэлт, гомдол, маргааныг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл шийдвэрлэнэ.

8.2. Энэ журмын 8.1-д заасны дагуу Эрчим үч хэмнэлтийн зөвлөлийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргаж болно.

ЭРЧИМ ХҮЧЭЭР АЖИЛЛАДАГ МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЦАХИЛГААН
 БАРААНД ЭРЧИМ ХҮЧНИЙ
 ХЭРЭГЛЭЭНИЙ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ, ШОШГОЖУУЛАХ,
 ХЯНАЛТ ТАВИХ ЖУРМЫН ХАВСРАЛТ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ШОШГЫН ХЭЛБЭР ХЭМЖЭЭ, ЗАГВАР

Харьцуулсан шошго


Харьцуулсан шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар 1 дүгээр зурагт, түүний хэмжээний харьцаа нь 2 дугаар зурагт дурдсаны дагуу миллиметрээр хэмжигдэнэ. Arial bold 12pt, uppercase, 100% хар.

I. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ШОШГО II. /Шошгын ангилал/ III. Бүтээгдэхүүний нэр: IV. Дугаар: хх-0хх/20хх	
V. Бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн нэр: VI. Бүтээгдэхүүний загвар:	VII. ЛОГО
VIII. 	IX. X. 0
XI. Эрчим хүчний зарцуулалт (кВт.ц/жил):	XII. 000
XI. Чадал (кВт):	XII. 000
XI. Техникийн үзүүлэлт (нэгж):	XII. 000
XI. Техникийн үзүүлэлт (нэгж):	XII. 000
XI. Байгаль орчны үзүүлэлт (нэгж):	XII. 000
XIII. Шошго олгосон эрх бүхий байгууллагын нэр:	XIV. ЛОГО
XV. Монгол улсын Засгийн газрын 20 .. оны ... дугаар тогтоолоор баталсан журмын дагуу олгов.	XVI. QR КОД

- I. Arial 10 pt, 100% хар.
- II. Arial bold 12 pt, 100% хар.
- III. Arial 10 pt, 100% хар.
- IV. Arial bold 12 pt, 100% хар.
- V. Arial bold 12 pt, 100% хар.
- VI. Үйлдвэрлэгчийн лого.
- VII. Эрчим хүчний хэрэглээний зэрэглэл.
- VIII. Зэрэглэлийн өнгөтэй ижил дэвсгэр өнгө.
- IX. Arial bold 46 pt, 100% цагаан.
- X. Arial 12 pt, 100% хар.
- XI. Arial bold 16 pt, 100% хар.

1 дүгээр зураг- Харьцуулсан шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар

Харьцуулсан шошго нь 160х90мм хэмжээнээс хэтрэж бөгөөд хэрэв том, эсхүл жижиг хэмжээгээр хэвлэх бол хэмжээний харьцаа алдагдахгүй байна.



2 дугаар зураг- Харьцуулсан шошгын хэмжээний үлгэрчилсэн загвар

Нотолсон шошго

Нотолсон шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар 3 дугаар зурагт, түүний хэмжээний харьцаа нь 4 дугаар зурагт дурдсаны дагуу миллиметрээр хэмжигдэнэ.




- I. Arial bold 12pt, uppercase, 100% хар.
- II. Arial 10 pt, 100% хар.
- III. Arial bold 12 pt, 100% хар.
- IV. Arial 10 pt, 100% хар.

- V. Эрчим хүчний үр ашигтайг нотлох тэмдэг.
- VI. Эрчим хүчний үр ашгийн стандартын дугаар.

- VII. Цахим дэлгэрэнгүй мэдээлэл.

3 дугаар зураг- Нотолсон шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар


Нотолсон шошго нь 65х90мм хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд хэрэв том, эсхүл жижиг хэмжээгээр хэвлэх бол хэмжээний харьцаа алдагдахгүй байна.



4 дүгээр зураг- Нотолсон шошгын хэмжээний үлгэрчилсэн загвар

Гэр тэмдэг

Тэмдгийн өнгөний формат СМҮК, дэвсгэр өнгө цагаан бөгөөд эрчим хүчний хэрэглээний зэрэглэл нь үр ашигтайгаас хамааран өөр өөр өнгөөр илэрхийлэгдэнэ.



RGB 0, 102, 51 эсхүл #006633

RGB 51, 204, 51 эсхүл #33cc33


RGB 255, 204, 0 эсхүл #ffcc00

RGB 255, 102, 51 эсхүл #ff6633

RGB 255, 51, 51 эсхүл #ff3333

5 дугаар зураг- Тэмдгийн загвар, өнгөний үлгэрчилсэн загвар, өнгөний код.

Тэмдэг нь 30х60мм хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд хэрэв том, эсхүл жижиг хэмжээгээр хэвлэх бол хэмжээний харьцаа алдагдахгүй байна.



6 дугаар зураг- Тэмдгийн үлгэрчилсэн загвар, түүний хэмжээс.